



# ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2018 оны 09 сарын 27 өдөр

Дугаар 13

Өндөрхаан

## ХЭЛЭЛЦСЭН НЬ.

Хурлыг 2018 оны 09 дүгээр сарын сарын 27-ны өдрийн 16 цаг 00 минутад аймгийн Засаг даргын зөвлөлийн өрөөнд төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүн Ж.Гантулга, Д.Эрдэнэбаатар, Г.Болд, Б.Сүнгээ, С.Бат-Эрдэнэ, нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Болормаа нарын бүрэлдэхүүнтэй төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн дарга Ж.Ганбаатар удирдан эхлүүлэв.

## ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

1. 2018 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн 152 дугаартай Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн албан бичгийн дагуу Өмнөдэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын дарга, Жаргалтхаан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга нарын сул орон тооны сонгон шалгаруулалт саналын дагуу товлогдон сонгон шалгаруулалтыг хойшлуулах тухай
2. Жаргалтхаан сумын 2018 оны 08 дугаар сарын 29-ний 16 тоот албан бичгээр ирүүлсэн зөрчил арилгуулах тухай

## СОНССОН НЬ 1:

Нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Болормаа:

2018 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр үдээс өмнө Төрийн албаны зөвлөлийн бичиг хэргийн ажилтан Цэцэгмаа холбогдон танай дээр 2 өргөдөл ирээд байна. Өмнөдэлгэр сумын иргэн Баярмаа, Жаргалтхаан сумын нарийн бичгийн даргын албан тушаал дээр. Үүний дагуу манай дээр хуралдаж байгаад үдээс хойш танайх руу ярина гэсэн. Хэсэг хугацааны дараа би Төрийн албан зөвлөл рүү утсаар ярин бүртгэлээ явуулах уу, яах уу гэдгийг асуухад тухайн шийдвэрлэх албан тушаалтан нь хуралд орсон байгаа тул одоохондоо шийдвэр гараагүй байна эргэж холбогдоё гэсэн. Үдээс хойш дахин төрийн албаны зөвлөлтэй холбогдоход Сосорбарам гэдэг хүн дээр шийдвэр нь гарна. Төрийн албаны зөвлөл дээр хуралтай байна. Журам хэлэлцэж ажил ихтэй байгаа тул 5, 6-аас нааш хурал тарахгүй тийм болохоор хариу хэлэх боломжгүй байна. Танайх нэгэнт зарласан болохоор бүртгэлээ явуулж байхгүй юу гэсэн хариу надад өгсөн байгаа.

Дарга Ж.Ганбаатар: төрийн албаны зөвлөлийнхөнтэй холбогдсон боловч журам хэлэлцэх хуралтай байна гэж байгаад 16 цаг 14 минутад Сосорбарамтай холбогдсон. Төрийн албаны зөвлөл дээр 2 өргөдөл очсон нь нэг Өмнөдэлгэр сумын Баярмаа, нөгөө нь ажлын байрны тодорхойлолтод өөрчлөлт оруулсан гэсэн Жаргалтхаан

сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Цогбатын гомдол. Үүнтэй холбоотой асуудлыг ярилцаад нөхцөл байдал бол тодорхой маргаан үүссэн байна тиймээс удирдах ажилтны сонгон шалгаруулалтыг хойшлуулах санал оруулж байна. Та хэд саналаа хэлээрэй.

Гишүүн Ж.Гантулга: Санал нэгтэй байна. Маргаан эцэслэн шийдвэрлэгдэх хүртэл сонгон шалгаруулалтыг хойшлуулсан нь дээр. Төв зөвлөл дээр гомдол очсон тул.

Гишүүн Д.Эрдэнэбаатар. Хойшлуулсан дээр.

Гишүүд: санал нэг байна.

Дарга Ж.Ганбаатар: Төрийн албаны зөвлөл дээр очсон гомдлыг хянан шийдвэрлэгдэх хүртэл хугацаагаар энэ хоёр ажлын байран дээр зарлагдсан сонгон шалгаруулалтыг хойшлуулъя. Хойшлуулах эрх нь бидэнд Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн жинхэнэ албаны удирдах албаны тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулах журмын 3 дахь хэсгийн 16-д Удирдах албан тушаалын сул орон тооны захиалгын тоо, ажлын зайлшгүй шаардлагыг харгалзан сонгон шалгаруулалт явуулах хугацааг Төрийн албаны Салбар зөвлөл тухайн үед нь шийдвэрлэж байна. Энэ талаар бүртгүүлэхээр ирсэн иргэдэд мэдээлэхийг Болормаад үүрэг болголоо.

#### ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Удирдах ажилтны сонгон шалгаруулалтыг маргаан эцэслэн шийдвэрлэгдэх хүртэл хугацаагаар хойшлуулах тогтоол гаргаад энэхүү шийдвэрийг төрийн албаны зөвлөлд хүргүүлэхийг Болормаад даалгасугай.

#### СОНССОН НЬ 2:

Дарга Ж.Ганбаатар: 2018 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн 16 дугаар албан бичгээр ирүүлсэн албан бичгээс харахад Б.Чинбат нь Жаргалтхаан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргаар ажиллаж байгаа нь тодорхой боллоо. Тийм болохоор Жаргалтхаан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргад зөрчил арилгуулах талаар хугацаа заасан албан бичиг хүргүүлъя.


#### ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Жаргалтхаан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд албан бичиг хүргүүлэх.

Хурал: 17:10 минутад дуусав.

ХУРАЛ УДИРДСАН:  Ж.ГАНБААТАР

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

ХӨТӨЛСӨН:  Ч.БОЛОРМАА

